



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Увс аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2026/008/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаангом хот 2026 он	Увс аймаг дахь Төрийн аудитын газар, Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn Аудитын менежер: М.Бат-Амгалан Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn Аудитор: Т.Батсүх Утас: 70453799, Цахим хаяг: Batsukht@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

- 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан
- 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан
- 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан
- 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан
- 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан
- 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

- 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
- 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
- 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
- 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд
- 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв
 - 3.5.1 Төсвийн төлөвлөлт
 - 3.5.2 Төсвийн гүйцэтгэл
 - 3.5.3 Нэмэлт төсөв
 - 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн
 - 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

4. АУДИТЫН ТАЙЛАН

- 4.1 Ерөнхий зүйл
- 4.2 Материаллаг байдал
- 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт
 - 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.5.1 Завсрын аудитын талаар
 - 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, Ө.Бадрахын гудамж
3 дугаар баг, Улаангом сум, Увс аймаг, 85165,

Утас/факс: 7045-3317,

Цахим шуудан: uvs@audit.gov.mn

УВС АЙМГИЙН ХҮҮХЭД,
ГЭР БҮЛИЙН ХӨГЖИЛ,
ХАМГААЛЛЫН ГАЗРЫН ДАРГА
Н.ӨЛЗИЙБАЯР ТАНАА

2026 02 04 № УВА-2026/008/НА-СТА-ТШЗ

танай _____-ны № _____-г

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Увс аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Увс аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

8525050068

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан/

төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>43,349,018.91</u>	<u>40,249,331.4</u>
33	АВЛАГА	723,091.51	1,926,476.00
335	Бусад авлага	723,091.51	1,926,476.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага		971,076.00
3351	Байгууллагаас авах авлага	723,091.51	955,670.00
35	БАРАА МАТЕРИАЛ	42,625,927.40	38,322,585.40
351	Түүхий эд материал	57,000.00	57,000.00
35130	Эм боох материал	57,000.00	57,000.00
354	Хангамжийн материал	42,568,927.40	38,265,585.40
35410	Бичиг хэргийн материал	669,500.00	876,500.00
35420	Аж ахуйн материал	41,599,427.40	33,728,085.40
35430	Сэлбэг хэрэгсэл		43,000.00
35470	Бусад хангамжийн материал	300,000.00	3,618,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>274,210,949.48</u>	<u>421,254,637.87</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	274,210,949.48	421,254,637.87
392	Биет хөрөнгө	274,210,949.48	313,874,637.87
39201	Барилга, байгууламж		4,533,905.00
39202	Хуримтлагдсан элэгдэл		-1,486,113.48
39203	Авто-тээврийн хэрэгсэл	142,988,026.00	142,988,026.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-23,437,500.00	-41,311,003.20
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	195,618,752.53	272,014,622.53
39206	Хуримтлагдсан элэгдэл	-78,705,483.05	-99,712,137.27
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	107,482,446.54	87,433,940.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-72,637,192.54	-56,946,726.64
39214	Бусад үндсэн хөрөнгө		10,976,949.15
39215	Хуримтлагдсан элэгдэл		-7,518,724.22
39217	Ном	2,901,900.00	2,901,900.00
393	Биет бус хөрөнгө		107,380,000.00
39301	Программ хангамж	720,000.00	720,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-720,000.00	-720,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө		107,160,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>317,559,968.39</u>	<u>461,503,969.27</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,750,000.00	5,176,756.51
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,750,000.00	5,176,756.51
413	Өглөг	1,750,000.00	5,176,756.51
41320	Ажиллагсадтай холбогдсон өглөг	00.00	173,361.00
4136	Бусад өглөг	1,750,000.00	5,003,395.51
41361	Байгууллагад төлөх өглөг	1,750,000.00	3,863,395.51
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	00.00	1,140,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>315,809,968.39</u>	<u>456,327,212.76</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	315,809,968.39	456,327,212.76
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	64,701,245.00	64,701,245.00
51101	Өмч: - төрийн	64,701,245.00	64,701,245.00
512	Хуримтлагдсан үр дүн	251,108,723.39	391,625,967.76
51210	Өмнөх үеийн үр дүн	251,108,723.39	251,108,723.39
51220	Тайлант үеийн үр дүн		140,517,244.37
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>317,559,968.39</u>	<u>461,503,969.27</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,246,652,304.00	2,449,185,688.99
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	177,511,266.00	199,730,413.99
120	Нийтлэг татварын бус орлого	177,511,266.00	199,730,413.99
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	177,511,266.00	199,730,413.99
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	177,511,266.00	199,730,413.99
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,069,141,038.00	2,249,455,275.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	975,829,600.00	2,031,942,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	975,829,600.00	2,031,942,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	93,311,438.00	217,512,675.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	6,996,000.00	36,000,000.00
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	70,138,000.00	165,609,300.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,177,438.00	15,903,375.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,069,345,496.10	2,308,668,444.62
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,069,345,496.10	2,308,668,444.62
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,016,861,105.51	2,118,366,950.83
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	549,003,000.00	1,326,160,248.67
210101	Үндсэн цалин	336,487,265.46	824,974,584.16
210102	Нэмэгдэл	146,248,034.54	285,069,281.06
210103	Унаа хоолны хөнгөлөлт	24,672,000.00	112,405,583.97
210104	Урамшуулал	41,595,700.00	103,710,799.48
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	67,775,259.97	165,652,263.28
210201	Тэтгэврийн даатгал	45,101,079.58	114,802,122.28
210202	Тэтгэмжийн даатгал	4,959,419.12	14,917,606.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,712,422.72	6,356,267.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,286,538.05	6,356,266.00
210205	Эрүүл мэндийн даатгал	11,715,800.50	23,220,002.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	106,275,723.35	150,181,448.28
210301	Гэрэл, цахилгаан	1,911,133.75	2,918,972.77
210302	Түлш, халаалт	14,876,538.60	24,755,080.00
210303	Цэвэр, бохир ус	8,368,051.00	4,947,395.51
210304	Байрны түрээс	81,120,000.00	117,540,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	51,657,001.00	94,198,355.00
210401	Бичиг хэрэг	7,312,410.00	16,331,350.00
210402	Тээвэр, шатахуун	33,362,430.00	39,464,642.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,112,999.00	5,560,421.00
210404	Ном, хэвлэлийн зардал		110,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,699,862.00	22,231,900.00
210408	Бараа материал ақталсны зардал	3,169,300.00	10,500,042.00
2105	Нормативт зардал	16,016,750.00	40,255,745.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,300,450.00	2,300,095.00
210502	Хоол, хүнс	14,716,300.00	29,676,650.00

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		8,279,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,268,600.00	4,810,000.00
210604	Урсгал засвар	9,268,600.00	4,810,000.00
2107	Томилолт, зочны зардал	13,610,100.00	62,229,415.00
210702	Дотоод албан томилолт	13,610,100.00	62,229,415.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	145,149,256.25	143,124,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	118,711,730.00	139,654,304.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	432,800.00
210803	Даатгалын үйлчилгээний төлбөр		106,920.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	25,268,526.25	260,476.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	737,000.00	2,670,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	58,105,414.94	131,754,975.60
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	350,950.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	26,905,461.00	67,987,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	31,169,553.94	63,416,725.60
210904	Найдваргүй авлагын алдагдал	30,400.00	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	52,484,390.59	190,301,493.79
2132	Бусад урсгал шилжүүлэг	47,489,897.00	30,664,600.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	46,189,897.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,300,000.00	30,664,600.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,994,493.59	159,636,893.79
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,994,493.59	159,636,893.79
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	177,306,807.90	140,517,244.37
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	177,306,807.90	140,517,244.37

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,069,141,038.00	2,249,455,275.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,069,141,038.00	2,249,455,275.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	975,829,600.00	2,031,942,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	975,829,600.00	2,031,942,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	93,311,438.00	217,512,675.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	6,996,000.00	36,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	70,138,000.00	165,609,300.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,177,438.00	15,903,375.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,042,345,038.00	2,239,047,275.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,042,345,038.00	2,239,047,275.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	989,388,544.41	2,060,711,781.21
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	548,489,125.34	1,231,089,891.67

210101	Үндсэн цалин	335,973,390.80	729,904,227.16
210102	Нэмэгдэл	146,248,034.54	285,069,281.06
210103	Унаа хоолны хөнгөлөлт	24,672,000.00	112,405,583.97
210104	Урамшуулал	41,595,700.00	103,710,799.48
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	68,177,786.47	153,162,288.75
210201	Тэтгэврийн даатгал	47,623,214.05	106,142,050.35
210202	Тэтгэмжийн даатгал	5,602,731.15	12,286,290.10
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,915,342.60	6,143,049.55
210204	Ажилгүйдлийн даатгал	2,434,659.35	5,718,936.35
210205	Эрүүл мэндийн даатгал	9,601,839.32	22,871,962.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	106,275,723.35	150,141,328.77
210301	Гэрэл, цахилгаан	1,911,133.75	2,918,972.77
210302	Түлш, халаалт	14,876,538.60	24,775,080.00
210303	Цэвэр, бохир ус	8,368,051.00	14,066,076.00
210304	Байрны түрээс	81,120,000.00	108,381,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,160,443.00	66,426,913.00
210401	Бичиг хэрэг	3,501,383.00	12,447,050.00
210402	Тээвэр шатахуун		36,273,642.00
210403	Шуудан холбоо	258,060.00	5,324,021.00
210404	Ном хэвлэл		136,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	401,000.00	12,336,200.00
2105	Нормативт зардал	2,006,310.00	32,943,695.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,006,310.00	2,300,095.00
210502	Хоол хүнс		19,931,100.00
210503	Нормын хувцас		10,712,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	200,000.00	3,216,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	200,000.00	
210604	Урсгал засвар		3,216,000.00
2107	Томилолт, зочны зардал		33,934,015.00
210702	Дотоод албан томилолт		33,934,015.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	256,999,645.25	340,729,749.02
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	230,562,119.00	337,520,029.02
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	432,800.00
210803	Даатгалын үйлчилгээ		106,920.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	25,268,526.25	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	737,000.00	2,670,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	96,800.00	49,067,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		420,950.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,079,511.00	48,646,950.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	52,956,493.59	178,335,493.79
2132	Бусад урсгал шилжүүлэг	47,962,000.00	18,698,600.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	46,662,000.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,300,000.00	18,698,600.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,994,493.59	159,636,893.79
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,994,493.59	159,636,893.79
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	26,796,000.00	10,408,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	26,796,000.00	10,408,000.00

22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	26,796,000.00	10,408,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	26,796,000.00	10,408,00.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	26,796,000.00	10,408,00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-26,796,000.00	-10,408,000.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2024 оны 01-р сарын 01-ээрх үлдэгдэл	64,701,245.00	00.00	73,801,915.49	138,503,160.49
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	64,701,245.00	00.00	73,801,915.49	138,503,160.49
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	177,306,807.90	177,306,807.90
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	64,701,245.00	00.00	251,108,723.39	315,809,968.39
D01	2025 оны 01-р сарын 01-ээрх үлдэгдэл	64,701,245.00	00.00	251,108,723.39	315,809,968.39
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	64,701,245.00	00.00	251,108,723.39	315,809,968.39
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	140,517,244.37	140,517,244.37
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	64,701,245.00	00.00	391,625,967.76	456,327,212.76

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,090,584,000.00	1,874,845,177.05	215,738,822.95
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,090,584,000.00	1,874,845,177.05	215,738,822.95

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,080,504,000.00	1,865,773,177.05	214,730,822.95
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,267,634,500.00	1,132,176,913.53	135,457,586.47
210101	Үндсэн цалин	681,777,300.00	669,447,454.23	12,329,845.77
210102	Нэмэгдэл	308,872,500.00	248,653,075.85	60,219,424.15
210103	Унаа хоолны хөнгөлөлт	143,859,00.00	110,365,583.97	33,493,416.03
210104	Урамшуулал	133,125,700.00	103,710,799.48	29,414,900.52
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	157,873,700.00	141,080,800.50	16,792,899.50
210201	Тэтгэврийн даатгал	107,403,500.00	97,874,027.70	9,529,472.30
210202	Тэтгэмжийн даатгал	12,635,800.00	11,313,583.20	1,322,216.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,317,800.00	5,656,698.10	661,101.90
210204	Ажилгүйдлийн даатгал	6,303,400.00	5,247,299.90	1,056,100.10
210205	Эрүүл мэндийн даатгал	25,213,200.00	20,989,191.60	4,224,008.40
2103	Байр ашиглалттай холбоотой зардал	117,596,200.00	117,531,000.0	65,200.00
210301	Гэрэл, цахилгаан	4,303,900.00	00.00	4,303,900.00
210302	Түлш, халаалт	20,022,900.00	9,631,000.00	10,391,900.00
210303	Цэвэр, бохир ус	7,275,600.00	9,158,800.00	-1,883,200.00
210304	Байрны түрээс	85,993,800.00	98,741,200.00	-12,747,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	69,972,700.00	55,406,913.00	14,565,787.00
210401	Бичиг хэрэг	21,326,200.00	12,447,050.00	8,879,150.00
210402	Тээвэр, шатахуун	32,178,700.00	36,273,642.00	-4,094,942.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,112,100.00	5,234,021.00	4,878,079.00
210404	Ном хэвлэл	3,631,700.00	136,000.00	3,495,700.00
210405	Хог хаягдал зайлуулах,хортон шавьж устгал ариутгал	1,075,500.00		1,075,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,648,500.00	1,316,200.00	332,300.00
2105	Нормативт зардал	32,907,400.00	27,943,695.00	4,963,705.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,841,200.00	2,300,095.00	1,541,105.00
210502	Хоол хүнс	18,951,800.00	19,931,100.00	-979,300.00
210503	Нормын хувцас зөөлөг эдлэл	10,114,400.00	5,712,500.00	4,401,900.00
2106	Эд хогшил худалдан авах	6,056,000.00	4,624,000.00	1,432,000.00
210601	Багаж техник хэрэгсэл	1,730,000.00	1,408,000.00	322,000.00
210604	Урсгал засвар	4,326,000.00	3,216,000.00	1,110,000.00
2107	Томилолт зочны зардал	33,922,300.00	26,025,000.00	7,897,300.00
210702	Дотоод албан томилолт	33,922,300.00	26,025,000.00	7,897,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	345,729,900.00	326,291,405.02	19,438,494.98
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	342,297,400.00	324,616,685.02	17,680,714.98
210802	Аудит баталгаажуулалт	432,800.00	432,800.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	107,500.00	106,920.00	580.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	192,600.00	0.00	192,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	29,600.00	00.00	29,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,670,000.00	1,135,000.00	1,535,00.00
2109	Бараа үйлчилгээний бусад	48,811,300.00	34,693,450.00	14,117,850.00

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	450,000.00	420,950.00	29,050.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	48,361,300.00	34,272,500.00	14,088,800
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,080,000.00	9,072,000.00	1,008,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,080,000.00	9,072,000.00	1,008,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,080,000.00	9,072,000.00	1,008,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,090,584,000.00	1,874,845,177.05	215,738,822.95
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,090,584,000.00	1,874,845,177.05	215,738,822.95
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,090,584,000.00	1,874,845,177.05	215,738,822.95

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		214,973,204.16	- 214,973,204.16
21	УРСГАЛ ЗАРДАЛ		214,973,204.16	- 214,973,204.16
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		205,346,604.16	- 205,346,604.16
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		98,912,978.14	-98,912,978.14
210101	Үндсэн цалин		60,456,772.93	-60,456,772.93
210102	Нэмэгдэл		36,416,205.21	-36,416,205.21
210103	Унаа хоолны хөнгөлөлт		2,040,000.00	-2,040,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		12,081,488.25	-12,081,488.25
210201	Тэтгэврийн даатгал		8,268,022.65	-8,268,022.65
210202	Тэтгэмжийн даатгал		972,706.90	-972,706.90
210203	ҮОМШӨ-ний даатгал		486,351.45	-486,351.45
210204	Ажилгүйдлийн даатгал		471,636.45	-471,636.45
210205	Эрүүл мэндийн даатгал		1,882,770.80	-1,882,770.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		32,610,328.77	-32,610,328.77
210301	Гэрэл, цахилгаан		2,918,972.77	-2,918,972.77
210302	Түлш, халаалт		15,144,080.00	-15,144,080.00
210303	Цэвэр, бохир ус		4,907,276.00	-4,907,276.00
210304	Байрны түрээс		9,640,000.00	-9,640,000.00
2104	Хангамж бараа материалын зардал		11,020,000.00	-11,020,000.00
210405	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл		11,020,000.00	-11,020,000.00
2105	Нормативт зардал		5,000,000.00	-5,000,000.00
210503	Нормын хувцас зөөлөн эдлэл		5,000,000.00	-5,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		9,000,000.00	-9,000,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		9,000,000.00	-9,000,000.00
2107	Томилолт зочны зардал		7,909,015.00	-7,909,015.00
210702	Дотоод албан томилолт		7,909,015.00	-7,909,015.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		14,374,450.00	-14,374,450.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		12,903,344.00	-12,903,344.00

210806	Мэдээлэл технологи		1,535,000.00	-1,535,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		14,374,450.00	-14,374,450.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		14,374,450.00	-14,374,450.00
213	Урсгал шилжүүлэг		9,626,600.00	-9,626,600.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		9,626,600.00	-9,626,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал		9,626,600.00	-9,626,600.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	214,973,204.16	-214,973,204.16
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		214,973,204.16	-214,973,204.16
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		36,000,000.00	-36,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		163,069,829.16	-163,069,829.16
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		15,903,375.00	-15,903,375.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0.00	0.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар нь “Хүүхэд, гэр бүлийн эрхийг дээдэлсэн, нийгмийн бүх бүлгийн оролцоог хангасан хүний хөгжлийн цогц бодлого хэрэгжүүлнэ” гэсэн зорилтын дор 4 зорилт, 51 арга хэмжээг гүйцэтгэхээр төлөвлөн ажилласан байна. Үүнд:

- Хүүхэд, гэр бүлийн хөгжил, оролцоог дэмжсэн урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг нэмэгдүүлэх.
- Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль.
- Төрийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг төрийн захиргааны болон хүний нөөцийн нэгдсэн удирдлагаар хангаж, төрийн үйлчилгээг иргэдэд тэгш, шударга, хүртээмжтэй хүргэнэ.
- Гэр бүл, хүүхэд, чиглэсэн төрийн үйлчилгээг ил тод, хурдан шуурхай, чанартай, хүртээмжтэй хүргэх.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд Хүүхдийн эрхийн тухай конвенц, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль, Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Нийгмийн даатгал болон Татварын тухай хууль, холбогдох журам, заавруудыг байгууллагын үйл ажиллагаандаа өдөр тутам хэрэгжүүлэн мөрдөж ажилладаг.

Тайлант хугацаанд санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуульд 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр, 07 дугаар сарын 09-ний өдөр,
- Татварын ерөнхий хуульд 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр,
- Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж болон, нягтлан бодох бүртгэлийн стандарт бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 143,944.0 мянган төгрөгөөр буюу 45.3 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	723.1	1,926.7	1,203.6
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	42,625.9	38,322.6	-4,303.3
Үндсэн хөрөнгө	274,210.9	421,254.6	147,043.7
Нийт хөрөнгө	317,560.0	461,504.0	143,944.00

Өр төлбөр	1,750.0	5,176.8	3,426.8
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	315,810.0	456,327.2	140,517.2
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	317,560.0	461,504.0	143,944.0

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэлгүй байна.

Авлагын дансны эхний үлдэгдэл нь 5 жил тутамд олгодог мөнгөн урамшууллын буруу тооцоноос үүссэн хувь хүний орлогын албан татварын 472.1 мянга, цалингийн ашиг илүү шилжүүлсэн 483.5 мянга, хувь хүнээс авах 971.1 мянга, нийт 1,926.7 мянган төгрөг байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 38,322.6 мянган төгрөг болж 4,303.3 мянган төгрөгөөр буурсан нь аж ахуйн материалын зарцуулалтаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн данс нь 421,254.6 мянган төгрөг болж 147,043.7 мянган төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй хүлээн авсан 207,501.0 мянга, төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 10,730.0 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, тайлант онд 63,416.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал тооцсонтой холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 5,176.8 мянган төгрөг болж 3,426.8 мянган төгрөгөөр өссөн нь 2,113.4 мянган төгрөгийн байгууллагад төлөх өглөг, 1,140.0 мянган төгрөгийн хувь хүмүүст төлөх өглөг, 173.4 мянган төгрөгийн ажилчидтай холбогдсон өглөг нэмэгдсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 456,327.2 мянган төгрөг болж 140,517.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,165,263.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалыг 636,021.6 мянга, нийгмийн даатгалын шимтгэлийг 79,502.7 мянга, байр ашиглахтай холбоотой зардалд 8,529.9 мянга, хангамж бараа материалын зардлыг 14,475.4 мянга, томилолтын зардлыг 32,604.0 мянга, эд хогшил, урсгал засварын зардлыг 27,264.7 мянга, норматив зардлыг 30.0 мянга, хичээл үйлдвэрлэлийн зардлыг 12,967.8 мянга, нэг удаагийн зардлыг 5,728.5, бусад зардлыг 62.3 мянган төгрөгөөр бууруулж, бусдаар гүйцэтгүүлэх бараа үйлчилгээний бусад зардлыг 908,766.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 2,256,842.7 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 166,258.7 мянган төгрөгөөр бууруулан тодотгол хийж төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,090,584.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,031,942.6 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,874,845.1 мянган төгрөг буюу 92.3 хувьтай байгаа нь Үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 96,248.6 мянга, Эрсдэлийн болон нөхцөл байдлын үнэлгээ хийх зардлын төсвийг 3,931.8 мянга, Хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээний зардлын төсвийг 27,958.9 мянга, Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын төсвийг 14,402.5 мянга, Хүүхдийн

хөгжил оролцооны зардлын төсвийг 8,256.3, мянга, Гэр бүлийн хөгжил хамгааллын зардлын төсвийг 6,299.7 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	72207-Хүүхдийн хөгжил, хамгаалал 80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	899,029.7	792,126.6	106,903.0	88.1%
2	80236-Эрсдэлийн болон нөхцөл байдлын үнэлгээ хийх	17,606.3	13,674.5	3,931.8	77.6%
3	80237-Хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээний зардал	179,819.3	151,860.4	27,958.9	84.4%
4	80238-Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал	88,476.9	74,074.4	14,402.5	83.7%
5	80240-Хүүхдийн хөгжил оролцоо	117,031.3	108,775.0	8,256.3	92.9%
6	80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж	368.1	0	368.1	0%
7	80102-Туслах үйл ажиллагаа	783,031.3	728,745.1	54,286.2	93%
8	72212-Гэр бүлийн хөгжил, хамгаалал	5,589.2	5,589.1	0,05	100%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Аудитын ерөнхий чиглэлийн судалгааны дүн

/мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Гүйцэтгэл	Тайлбар
1	Программ хангамжийн бүртгэл	220.0	Acoluos
2	Унаа, хоолны зардал	112,405.6	Ажилтнуудад хоолны хөнгөлөлт 12.0 мянган төгрөгөөр тооцон олгож байна.
3	Сургалт, семинар, хурал цуглаан	58,139.3	Тус байгууллага нь тайлант онд сургалт, семинар, хурал цуглааны зардалд 58,139.3 мянган төгрөг зарцуулсан байна.
4	Гадаад томилолт, арга хэмжээ	0.0	Гадаад томилолтын зардал байхгүй байна.
5	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал	0.0	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй байна.
6	Орон тооны цомхотгол	0.0	Орон тооны цомхотгол хийгдээгүй байна.
7	Хэвлэл, мэдээлэл	5,700.0	Тайлант онд "Сама-Увс" телевизтэй 2,400.0 мянга, МБС ТВ-тэй 3,300.0 мянган төгрөгөөр тус тус хамтран ажиллах гэрээ байгуулсан байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус газрын нэмэлт санхүүжилтийн дансанд ХГБХХЕГ-аас хүүхэд харах үйлчилгээний санхүүжилт 12,903.4 мянга, хүүхдийн санал санаачлагыг дэмжих төслийн санхүүжилт 3,000.0 мянга, Кристина нобелийн хүүхдийн сангаас 8,000.0 мянга, Уул усны диваажин ТББ Увс-100

хүүхдийн баярын арга хэмжээний санхүүжилт 28,000.0 мянга, аймгийн ЗДТГ-аас түр хамгаалах байрны санхүүжилт 130,635.8 мянга, Төрийн захиргааны албан хаагчдад олгох орон нутгийн нэмэгдэлд 17,973.5 мянга, сургалт нөлөөллийн ажлын санхүүжилт 7,000.0 мянга, аймаг болон улаангом сумын ИТХ -аас сургалт нөлөөллийн ажлын санхүүжилт 10,000.0 мянга, нийт 217,512.7 төгрөгийн орлогыг зарцуулах эрх нээлгэн 214,973.2 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулж, 2,539.5 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд тендер худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй, харин байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах 201,516.1 мянган төгрөгийн бараа материал, 10,730.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж шууд худалдан авалт хийсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Увс аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Батсүх гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Увс аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 18 дугаар албан бичгээр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,069,345.5 мянган төгрөгийн 1 хувиар буюу 10,693.5 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 8,554.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,308,688.4 мянган төгрөгийн 1 хувиар буюу 23,086.7 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 18,469.3 мянган төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Увс аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил гараагүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар нь шилэн дансны цахим хуудаст Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 15,868.7 мянган төгрөгийн 2 мөнгөн гүйлгээ, төсөв, хөрөнгө зарцуулах 717.5 мянган төгрөгийн 1 шийдвэрийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст байршуулаагүй байна. Мөн цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 974,102.3 мянган төгрөгийн 34 мөнгөн гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 216,958.2 мянган төгрөгийн 21 мөнгөн гүйлгээ, төсөв, хөрөнгө зарцуулах 250,270.8 мянган төгрөгийн 30 шийдвэрийн мэдээлэл, байгууллагын батлагдсан төсвийн 2,256,842.7 мянган 1 мэдээллийг шилэн дансны цахим хуудаст тус тус хугацаа хоцроон байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэхгүй байна гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Увс аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар нь Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгосон ажилтан болох Захиргаа хүний нөөц хариуцсан ахлах мэргэжилтэн, Гэр бүлийн хөгжил хариуцсан ахлах мэргэжилтэн зэрэг ажлын байранд ажиллаж байгаа хоёр ажилтны хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах 6,197.5 мянган төгрөгийн орлогыг нийгмийн даатгалын 2 дугаар сарын тайланд тайлагнахдаа даатгуулагчийн төрлийг буруу сонгож 70011 / Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгосон ажилтан (тэтгэврийн даатгалын шимтгэл төлөхгүй)/ кодоор тайлагнасан байна. Тус асуудлыг шийдвэрлүүлэхээр аймгийн Нийгмийн даатгалын газарт албан бичиг хүргүүлэхээр боллоо.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Увс аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын 2025 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 30,009.0 мянган төгрөгийн 3 зөрчил илэрснээс 25,760.1 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 4,248.9 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоосон байна. Төлбөрийн актын биелэлтийг Увс аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 213 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Увс аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар нь “ЭМАЗ” ХХК-ийн байранд түрээсийн гэрээгээр сард 9,640.0 мянган төгрөг, жилд нийт 115,680.0 мянган төгрөгийг төлж үйл ажиллагаагаа явуулж байна.

Увс аймгийн Засаг даргын 2025 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн 1/1408 дугаар албан бичгээр Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан “Бизнес хөгжлийг дэмжих төв”-ийн зориулалтаар 2024 онд ашиглалтад орсон оффисын шинэ байранд Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрыг байрлуулах асуудлыг судлан шийдвэрлэх асуудлыг Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын даргад хүргүүлсэн байна. Ингэснээр орон нутгийн төсвийн төсвийн үр ашигтай байдлыг хангах, “Бизнес хөгжлийг дэмжих төв”-ийн түрээсийн зардлыг уг байрны дулааны зардалд зарцуулах боломж бүрдэхээр байна.

Энэ асуудлыг судалж шийдвэрлэсэн эсэхийг дараагийн аудитаар анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 3,714,760.2 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж өглөө.

5.1 Зөвлөмж

Илрүүлэлт:

Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 15,868.7 мянган төгрөгийн 2 мөнгөн гүйлгээ, төсөв, хөрөнгө зарцуулах 717.5 мянган төгрөгийн 1 шийдвэрийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст байршуулаагүй байна. Мөн цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 974,102.3 мянган төгрөгийн 34 мөнгөн гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 216,958.2 мянган төгрөгийн 21 мөнгөн гүйлгээ, төсөв, хөрөнгө зарцуулах 250,270.8 мянган төгрөгийн 30 шийдвэрийн мэдээлэл, байгууллагын батлагдсан төсвийн 2,256,842.7 мянган төгрөгийн нэг мэдээллийг шилэн дансны цахим хуудаст тус тус хугацаа хоцроон байршуулсан байна.

Өгсөн зөвлөмж:

Цаашид Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмыг хэрэгжүүлэн ажиллах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайлан хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо
Дүн													

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Шилэн дансны цахим хуудаст 3 мэдээлэл байршуулаагүй, 86 мэдээлэл хугацаа хоцроон байршуулсан байна.	1	3,714,760.2						1	3,714,760.2
Дүн	1	3,714,760.2						1	3,714,760.2
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
Дүн									
Нийт дүн									

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

АУДИТЫН ТАЙЛАНГ



М.БАТСУУРЬ/

М.БАТ-АМГАЛАН/

/Т.БАТСҮХ/

2026 оны 02 дугаар сарын 04-ний өдөр